



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



**СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ДАГУУ ХУВИАРЛАСАН Ч
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАНД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА.**

*Ховд хот
2017 оны 8 сар*

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар 2017 оны 6 дүгээр сар Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432736 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар 3 давхар	Товчилсон үгийн тайлбар..... 2 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл..... 3 Бүлэг 1 Сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан ч зарим хэсгийн хороодод санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна..... 5-10 Бүлэг 2. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан ч хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт сул байна.....10-11 Аудитын дүгнэлт.....11 Аудитын зөвлөмж.....11-12 Тэргүүлэх аудиторын тушаал Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
--	--

Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол улсын
ҮАГ	Үндэсний Аудитын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ОӨУБЕГ	Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
МТБ	Мэдээлэл технологийн баг
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл

1.1.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

1.2Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан эсэх.
- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх.

1.3 Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороодод улсын төсвөөс олгосон хөрөнгийн санхүүжилт, зарцуулалт, тайлагнал, хяналт шалгалтын баримтуудыг хамруулав.

1.4 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан тооцоолол хийх, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс бүртгэлд тусгасан эсэх, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

Аудитын талбарын ажлыг 07 дугаар сарын 25-наас, тайлагналын үе шатны ажлыг 08 дугаар сарын 10-наас эхлэн гүйцэтгэв. Тайлангийн нэгтгэлийг 2017 оны 08 дугаар сарын 16-ны дотор дуусгаж, үе шатны хяналтаар оруулж баталгаажуулан ҮАГ-ын НАГ, Аймгийн сонгуулийн хороо болон холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”, СЕХ-ноос батлан гаргасан бусад журам, заавар, зөвлөмж болон бусад холбогдох хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

1.5 Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Галбадрах, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар удирдан, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Д.Мөнхтулга, Б.Дамчуубалжир, Ц.Аззаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Сонгуулийн ерөнхий хороо нь Сонгуулийн тухай хуулийн 31.4¹ дэх заалтын дагуу 2017 оны 04-р сарын 12-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Ховд аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 33.4² дэх заалтын дагуу 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 2 дугаар тогтоолоор сумдын Сонгуулийн хороог 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, сумдын Сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 35.2³, 35.3⁴ дах заалтын дагуу 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэсгийн хороог тус тус байгуулсан байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн Ховд аймгийн Сонгуулийн хорооны төсвийг 365.8 сая төгрөгөөр батлагдаж хуваарилсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн анхан шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй тул хоёр дахь шатны санал хураалтыг 2017 оны 7 дугаар сарын 7-нд явуулахаар тогтоожээ.

Эхний шатны санал хураалтанд 33412 иргэн буюу 63,93 хувь нь саналаа өгсөн дахин санал хураалтанд 30151 иргэн буюу 57,69 хувь нь саналаа өгсөн байна.

СХХ нь хоёр дахь шатны санал хураалт явуулах зардалд аймгийн СХ-нд 135.8 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж хуваарилсан байна.

ОӨУБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, бүртгэх, цахим мэдээллийн санд байрлуулах, санал авах техник хэрэгслийг татаж авах, сумдын СХ-нд хүргүүлэх, итгэмжлэгдсэн албан хаагчдын сургалт зохион байгуулах болон унаа, хоол, томилолтын зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 75.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт санал авах байр болон саналын хуудас хүлээн авах, хүлээлгэн өгөх үеийн хамгаалалтад ажиллах цагдаагийн албан хаагчдын хоол, шатахуун, холбооны зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 14.1 сая төгрөгийг санхүүжилтийг олгосон байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Ховд аймагт нийт дүнгээрээ 590,7 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгожээ.

¹ Сонгуулийн төв байгууллага аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр, санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

² Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

³ Санал авах байр нь ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч гэсэн орон тоотой, таваас долоон хүний бүрэлдэхүүнтэй байна.

⁴ Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал авах байрыг санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, ахлах зохион байгуулагчийг томилно.

БҮЛЭГ 1. Сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан ч зарим хэсгийн хороодод санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.

1.1 Ерөнхийлөгчийн сонгуулийн төсвийн зардлын зүйлийг зохих журмын дагуу хуваарилжээ.

Ховд аймгийн сонгуулийн хороонд Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2 шатны санал хураалтын зардалд 501.6 сая төгрөгийг хуваарилжээ.

Сонгуулийн эхний шатны санал хураалтын зардлын санхүүжилтийг СЕХ-ны 2017 оны 04-р сарын 26-ны өдрийн 113 дугаар тоот албан бичгээр 34.7 сая төгрөгийн, 2017 оны 05-р сарын 30-ны өдрийн 172 дугаар тоот албан бичгээр 89.2 сая төгрөгийн, 2017 оны 06-р сарын 13-ны өдрийн 199 дугаар албан бичгээр 34.4 сая 2017 оны 06 сарын 21-ны өдрийн 210 дугаар албан бичгээр 202.4 сая төгрөгийн, санал тоолох төхөөрөмж буцаан татах зардалд 5.1 сая төгрөгийн санхүүжилт олгож нийт 365.8 сая төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд хуваарилан батлагдаж, бүрэн олгосон байна.

Сонгуулийн 2 дахь шатны санал хураалтын зардлын санхүүжилтийг СЕХ-ны 2017 оны 7 дугаар сарын 3-ны 260 дугаар тоот албан бичгээр 48.4 сая төгрөг, 2017 оны 7 дугаар сарын 18-ны 295 тоот албан бичгээр 87,4 нийт 135.8 сая төгрөгийг СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд хуваарилж, олгосон байна.

1.2 Сумдад Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох журмын дагуу хуваарилсан байна.

Нийт 17 сумын 92 хэсгийн хороодод 436.6 сая төгрөг буюу 87.1 хувийг, аймгийн сонгуулийн хороонд 65.0 сая төгрөг буюу 12.9 хувийг зарцуулахаар тус тус хуваарилжээ.

Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-д заасны дагуу сонгогчийн тоо, санал авах хэсгийн хорооны тоо, газар нутгийн алслалт зэргийг харгалзан сумдын сонгуулийн зардлыг хуваарилсан байна.

Сонгуулийн тухай хуульд заасны дагуу сумдын санал авах хэсгийн хорооны бүрэлдэхүүн, санхүүжилтийг хүснэгтээр харуулбал: /сая.төг/

Д/д	Сумдын нэр	Сонгогчийн тоо	Хэсгийн тоо	Ажилласан хүний тоо	Анхан шатны сонгууль		Дахин сонгууль	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Алтай	1,930	4	35	16.0	16.0	7.1	7.1
2	Булган	5,943	6	55	22.3	22.3	8.8	8.8
3	Буянт	2,178	5	39	16.4	16.4	6.6	6.6

4	Дарви	1,713	5	47	18.8	18.8	7.9	7.9
5	Дөргөн	1,740	4	31	13.1	13.1	5.5	5.5
6	Дуут	1,211	4	31	13.3	13.3	5.7	5.7
7	Зэрэг	1,943	5	39	16.4	16.4	6.8	6.8
8	Манхан	2,445	6	49	19.5	19.5	8.2	8.2
9	Мөнххайрхан	1,351	4	31	13.8	13.8	6.0	6.0
10	Мөст	1,898	5	37	16.5	16.5	7.1	7.1
11	Мянгад	2,132	5	41	17.1	17.1	7.3	7.3
12	Үенч	2,356	6	47	21.4	21.4	9.2	9.2
13	Ховд	2,018	5	37	15.3	15.3	5.8	5.8
14	Цэцэг	1,777	5	47	18.8	18.8	8.1	8.1
15	Чандмань	1,819	6	43	18.3	18.3	7.3	7.3
16	Эрдэнэбүрэн	1,537	5	37	16.1	16.1	7.0	7.0
17	Жаргалант	18,273	12	103	34.9	34.9	14.3	14.3
18	Аймаг			31	58.0	54.5	7.1	5.6
	нийт	52,264	92	780	365.8	362.3	135.8	134.3

Нийт 92 хэсгийн хороодыг байгуулахдаа аймаг, сумдын сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 23.2 дахь заалтыг мөрдөн ажилласан байна

1.3 Аймаг сумдын сонгуулийн зардалд 496.7 сая төгрөгийг зарцуулжээ.

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос эхний санал хураалтанд 365.8 сая, дахин сонгуулийн санал хураалтанд 135.8 сая бүгд 501.6 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авч гүйцэтгэлээр 496.7 сая төгрөгийг зарцуулж 4.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлыг аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 38.2⁵ дахь заалтын дагуу зардлын зүйл тус бүрээр ангилж зарцуулсан байна.

Эхний шатны зарцуулалтыг төлөвлөгөө гүйцэтгэлээр харуулбал: /сая.төг/

⁵ 38.2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:
38.2.19.сонгуулийг зохион байгуулахтай холбогдсон бусад зардал.

Д/д	Зардлын нэр	Аатлагдсан	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сургалтын зардал	18.1	17.5	0.6
2	Тогтоол, протокол,бусад маягт хэвлүүлэх	0.3	0.4	(0.1)
3	Бичиг хэргийн зардал	20.8	20.8	-
4	Шуудан холбооны зардал	19.9	19.9	-
5	Унааны зардал	36.4	35.9	0.5
6	Сурталчилгааны зардал	8.0	8.0	-
7	Сурталчилгааны материал хүргүүлэх зардал	2.1	2.1	-
8	Санал авах байр бэлтгэх зардал	18.4	18.4	-
9	Саналын хуудас устгах зардал	0.5	0.5	-
10	Саналын хуудас хүргэх	4.3	4.3	-
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	16.5	16.5	-
12	Мэдээ дамжуулах зардал	5.4	5.1	0.3
13	Томилолтын зардал	5.9	5.7	0.2
14	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3.9	3.9	-
15	Болзошгүй зардал	3.0	3.0	-
16	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	172.3	170.4	1.9
17	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	30.0	30.0	-
НИЙТ ДҮН		365.8	362.3	3.4

Дээрх хүснэгтээс харахад сургалтын, унааны, мэдээ дамжуулах, томилолтын болон сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардлыг нийт дүнгээр нь 3.5 сая төгрөгөөр хэмнэж, тогтоол, протокол бусад маягт хэвлүүлэх зардлыг 0,1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Дахин сонгуулийн зарцуулалтыг төлөвлөгөө гүйцэтгэлээр харуулбал: /сая.төг/

Д/д	Зардлын нэр	Нийт төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Бичиг хэргийн зардал	1.8	1.8	-
2	Шуудан холбооны зардал	2.3	2.3	-
3	Унааны зардал	13.7	14.2	(0.56)
4	Саналын хуудас хүргэх	4.3	4.3	-
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	9.7	9.7	-
6	Мэдээ дамжуулах зардал	5.4	5.4	-
7	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3.9	3.9	-
8	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	15.8	15.8	-
9	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	79.0	77.0	2.02
НИЙТ ДҮН		135.8	134.3	1.5

Дахин сонгуулиар сонгуулийн хороод унааны зардлыг 0.6 сая төгрөгөөр хэтрүүлэн, сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардлыг 2.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

1.4 Аймгийн сонгуулийн хороо болон сумдын салбар хороодын төсвийн зарцуулалтанд тавих хяналт сул байна.

- Аймгийн сонгуулийн хорооны төрийн сан банкин дахь 100160022001 тоот дансанд 4.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.3-д заасны дагуу санал хураалт явагдсанаас хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын зарцуулаагүй үлдэгдлийг СЕХ-ны дансанд төвлөрүүлнэ гэсэн заалтыг зөрчсөн тул СЕХ-ны дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.
- СЕХ-ны 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 295 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралтанд зааснаар сонгуулийн хороонд ажилласан ажилтануудын урамшуулалыг хүн бүрээр нь гаргаж тухайн хүний цалингийн болон хувийн харилцах дансанд шилжүүлэхээр зөвлөмж хүргүүлсэн байхад Чандмань, Цэцэг сумдын сонгуулийн хороо нь эд хариуцагчийн харилцах дансаар дамжуулан бэлнээр, мөн Үенч, Чандмань, Цэцэг сумдын сонгуулийн хороо нь шатахуун, томилолтын зардлуудыг бэлнээр авч олгосон байна.
- Сонгууль зохион байгуулахтай холбоотой зайлшгүй шаардлагатай 4.6 сая төгрөгийн БҮТЭЗ, санал авах байр тохижуулах зардлаар Мөст, Дуут, Ховд, Манхан сумдын сонгуулийн хороо нь 1.2 сая төгрөгийн принтер, ус буцалгагч худалдан авсныг холбогдох сумдын ИТХ-н ажлын алба, болон ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаагүй, хүлээлгэн өгөөгүй байна.
- Томилолтын хуудас засвартай, ирсэн буцсан өдөр тэмдэглээгүй, аймгийн сонгуулийн хорооны даргын гарын үсэг зураагүй, тамга тэмдэг дарж баталгаажуулаагүй анхан шатны баримт бүрэн бүрдүүлээгүй томилолтын хуудсаар 0.6 сая төгрөгийг Зэрэг, Дөргөн, Ховд, Дуут, Чандмань сумдын сонгуулийн хороо нь томилолтын зардалд олгожээ.
- Мөст, Зэрэг, Эрдэнэбүрэн, Дарви сумдын сонгуулийн хороо нь сонгуулийн хороонд ажилласан ажилтануудад хоолны урамшуулалыг олгосон боловч хоолны зардалд 1.1 сая төгрөгийн хоолны зардлыг гаргажээ.
- Үенч сумын сонгуулийн хороо нь сонгуульд ажилласан ажилтануудын урамшууллаас ХАОАТ-ыг суутган авсан ч холбогдох татварын байгууллагад шилжүүлээгүй, аймгийн сонгуулийн хорооноос зөвшөөрөл авахгүйгээр 1.0 сая төгрөгийг шатахууны зардалд гүйлгэн зарцуулжээ.
- Аймгийн сонгуулийн хороо нь 3.8 сая төгрөг, Дуут сумын сонгуулийн хороо нь 3.7 сая төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан боловч замын хуудас бичээгүй, жолоочийн тооцоо бодоогүй байна.
- Дөргөн, Чандмань, Мөст, Дуут, Эрдэнэбүрэн Дарви, Цэцэг, Жаргалант сумдын сонгуулийн хороо нь томилолтын мөнгө илүү олгосон, ажлын хөлснөөс ХАОАТ суутгаагүй, буудлын мөнгө олгосон, аймгийн сонгуулийн хороо нь шатахууны мөнгө илүү шилжүүлсэнтэй холбоотой 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо

- Аймгийн сонгуулийн хорооны гишүүдэд хоолны урамшуулал олгосон ч хоолны зардлыг давхардуулан гаргасанд 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Аудитаар аймгийн сонгуулийн хороо болон сумдын сонгуулийн хороодын зарцуулалттай холбоотой 20.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 7.2 сая төгрөгийн төлүүлэх төлбөрийн акт, 7.5 сая төгрөгийн албан шаардлага, 5.8 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

1.5 Аймгийн Цагдаагийн газар нь шуудан холбоо, хоолны зардлыг зөрүүтэй тооцож олгожээ.

Сонгуулийн тухай хуулийн 38.4 -д заасны дагуу ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санал авах байр, сонгуулийн тоног төхөөрөмж болон саналын хуудас хүлээж авах, хүлээлгэн өгөх үеийн хамгаалалтад ажиллах цагдаагийн алба хаагчдын хоол, шатахуун, холбооны зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 14.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая.төг/

Д/д	Зардлын нэр	Анхан шатны сонгууль		Дахин сонгууль	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Шатахуун	1.2	1.2	1.2	1.2
2	Шуудан холбоо	0.8	0.8	1.1	1.1
3	Хоол			9.8	9.8
	дүн	2.0	2.0	12.1	12.1

Гүйцэтгэлийн тайланг холбогдох анхан шатны баримтуудтай тулгахад шуудан холбоо, хоолны алба хаагчдад 0,5 сая төгрөгийг илүү, 0,5 сая төгрөгийг зарим алба хаагчдад олгоогүй зөрчил дутагдал илэрсэн тул төлбөрийн акт бичлээ.

1.6 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгуулийн зардлыг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.3-д заасны дагуу ОӨУБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэсийн нэмэлт санхүүжилтийн дансаар эхний шатны санал хураалтын зардалд 50.9 сая, дахин санал хураалтын зардалд 24.1 сая төгрөгийн нийт 75.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилтийн төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая.төг/

№	Зардлын ангилал	Анхан шатны сонгууль		Дахин сонгууль	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бичиг хэрэг	3.4	3.4	3.7	3.7
2	Томилолт, шатахуун, шуудан	6.8	6.8	4.4	4.4
3	Итгэмжлэгдсэн ажилтаны цалин, хоол	31.3	31.3	16.1	16.1
4	Хурууны хээ унших төхөөрөмж авчрах, буцаан хүргэж өгөх зардал	4.9	4.9		
5	Сургалт	4.4	4.4		
	Нийт дүн	50.9	50.9	24.2	24.2

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь дээд шатны байгууллагаас ирсэн санхүүжилтийг хуулийн дагуу зарцуулж тайлагнасан байна.

БҮЛЭГ 2. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан ч хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт сул байна.

2.1 Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу сумдын сонгуулийн хороод нь сонгуулийн төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, аймгийн сонгуулийн хороонд нэгтгүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороод нь Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн архивласан нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.1 дэх “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, ...” гэж заасантай нийцэж байна.

2.2 Сонгуулийн төсвийн зарцуулалтанд тавих хяналт сул байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4-д “..., аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн хороонд тухай бүр нь төсвийн зарцуулалтын задаргаа болон зөвлөмжийг хүргүүлж ажилласан боловч хяналт хийсэн тухай ажлын тайлан байхгүй байна.

Аймгийн сонгуулийн хороонд сумдын сонгуулийн төсвийн гүйцэтгэлийн тайланг албан бичгээр хүлээлгэж өгөөгүй, бүх сумдын сонгуулийн хороо тайлангийн товч танилцуулга, тодруулгыг тус тус ирүүлээгүй байна.

Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.3-д “Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комиссын сонгуулийн зардлын тайлан дараах хэсгээс бүрдэнэ;”, 4.3.1-д “сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг”, 4.3.2-д “тайлангийн товч танилцуулга, тодруулга;” гэсэн заалттай нийцэхгүй байгаа нь аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланг холбогдох журмын дагуу хянаж хүлээн аваагүйг харуулж байна.

Аудитаар нийт 21,1 сая төгрөгний төлбөр зөрчил илэрснээс 7,8 сая төгрөгийн акт, 7.5 сая төгрөгний албан шаардлага, 5.8 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- 1. Сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан ч зарим хэсгийн хороодод санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.***
- 2. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан ч хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт сул байна.***

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Сонгуулийн хорооны дарга Л.Батбаяр, нягтлан бодогч Б.Даваадорж нарт

- Сумдын сонгуулийн хорооны тайланг холбогдох журамд заасны дагуу хүлээн авч, хяналт тавин ажиллах
- Сонгуулийн зардлаар бэлтгэсэн тоног төхөөрөмж болон БҮТЭЗ-ийг холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх
- Шатахууны зарцуулалт болон бусад зардлуудын анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн бүрдүүлэн ажиллах
- Сумдын СХ-ны зардлыг ангилал хооронд гүйлгэн зарцуулах шийдвэрийг зохих журмын дагуу гаргаж хүргүүлж байх

ХОА/2017/-04-НА

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл

- Сумдын сонгуулийн хорооны гишүүдийг томилохдоо нягтлан бодогч мэргэжилтэй хүнийг оруулан баталж сонгуулийн хорооны нягтлан бодогчийн ажлыг хавсруулан ажиллуулах
- Цагдаа, улсын бүртгэлийн хэлтсийн сонгуулийн хэсгийн хороодод ажиллаж буй алба хаагчдын Үндсэн хуулиар олгогдсон саналаа өгөх эрхийг ханган ажиллах

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР Д.НАРАНТУУЛ

АУДИТОР Д.МӨНХТУЛГА

АУДИТОР Б.ДАМЧУУБАЛЖИР

АУДИТОР Ц.АЗЗАЯА



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 25

Ховд

Аудитын тайлан, зөвлөмж, акт,
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан "акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1, 4.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын дэргэдэх зөвлөлийн 2017 оны 08 сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн аймгийн Сонгуулийн хорооны дарга Л.Батбаяр, нягтлан бодогч Б.Даваадорж нарт ДААЛГАХ нь:

2.1 Сумдын сонгуулийн хорооны тайланг холбогдох журамд заасны дагуу хүлээн авч, хяналт тавин ажиллах.

2.2 Сонгуулийн зардлаар бэлтгэсэн тоног төхөөрөмж болон БҮТЭЗ-ийг холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх.

2.3 Шатахууны зарцуулалт болон бусад зардлуудын анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн бүрдүүлэн ажиллах.

2.4 Сумдын СХ-ны зардлыг ангилал хооронд гүйлгэн зарцуулах шийдвэрийг зохих журмын дагуу гаргаж хүргүүлж байх.

2.5 Сумдын сонгуулийн хорооны гишүүдийг томилохдоо нягтлан бодогч мэргэжилтэй хүнийг оруулан баталж сонгуулийн хорооны нягтлан бодогчийн ажлыг хавсруулан ажиллуулах.

2.6 Цагдаа, улсын бүртгэлийн хэлтсийн сонгуулийн хэсгийн хороодод ажиллаж буй алба хаагчдын Үндсэн хуулиар олгогдсон саналаа өгөх эрхийг ханган ажиллах.

3. Нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

0800002

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Нарантуулд даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ГАЛБАДРАХ



ХОВД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО

84000 Ховд, Ховд аймаг
Утас: 7043-2964 Факс: 076-7043-2964

2017.08.16 № 73
танай _____-ны № _____-т

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын газраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зарцуулалтын тайланд нийцлийн аудит хийсэн тухай дүгнэлттэй танилцлаа.

Бид дүгнэлтээр гарсан зөвлөмж, шаардлага, актыг хүлээн зөвшөөрч байна.

Сумдын санхүүгийн тайлан хугацаанаас хоцорч ирснээр аймгийн нэгтгэлийн хугацаа хожигдсон цаашид энэ ажлыг сонгуулийн дүнтэй хамт авах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах болно.

ДАРГА  Л.БАТБАЯР